



**Үндэсний Аудитын газрын харъяа
Хэнтий аймгийн Аудитын газар**

Аудитын тайлан

**УЛСЫН ИХ ХУРАЛ БОЛОН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2016 ОНЫ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ- УАГ-ГАГ-/2016/07-ГА-ХЭ**

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	АГУУЛГА	ХУУДАС
	Товчилсон үгийн тайлбар	2
Хэнтий аймгийн аудитын газар	ТАНИЛЦУУЛГА	3
	Аймгийн Сонгуулийн хорооны талаарх товч танилцуулга	3
Аймгийн тэргүүлэх аудитор Ц.Энхтүвшин	Гүйцэтгэлийн аудит хийх болсон шалтгаан	3
	АУДИТ ХИЙГДСЭН ТУХАЙ	
Аудитын менежер Б.Наранцэцэг	Аудитын зорилго	3
	Аудитын цар хүрээ	4
Аудитор Ү.Төгсжаргал	Аудитад ашигласан арга аргачлал	4
	Эрсдлийн үнэлгээ	4
2016 оны 7 дугаар сар	Аудитын гол ба дэд асуудлууд,	
	Аудитад хамруулсан баримт, материал	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7056-2147 дугаарын утас, 7056 -2112 дугаарын факсаар харилцана уу	АУДИТЫН ГОЛ АСУУДЛУУД БА ИЛРҮҮЛСЭН ЗҮЙЛС	
	Бүлэг 1: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу арвилан, хэмнэлттэй зарцуулсан эсэх	5
ХАЯГ:	1.1 Улсын бүртгэл, Статистикийн газарт хуваарилагдан ирсэн сонгуулийн зардлын бичиг хэргийн зардлаас Шуудан үйлчилгээний газарт төлөх 2015 оны жилийн эцсийн 4531.9 мянган төгрөгийн өрийг барагдуулж зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.	
	Бүлэг 2: Төсвийн гүйцэтгэлийг бодитой тайлагнасан эсэх	7
Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 3 давхар, 315 тоот	2.1 Аймгийн Сонгуулийн хорооны үйл ажиллагааны зардал нийт дүнгээрээ хэтрээгүй бөгөөд 2761.4 мянган төгрөгийг Сонгуулийн ерөнхий хороонд төвлөрүүлсэн байна.	
	Бүлэг 3: Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй эсэх	8
	3.1 Аймгийн Сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны гүйцэтгэлийн тайлан, анхан шатны баримтыг хүлээж авсан боловч сонгуулийн зардлаас хэдэн төгрөгийн бараа материал бэлтгэсэн, хаана орлого авсан талаарх мэдээлэл хангалтгүй байгаа зэргээс харахад хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байна.	
	НЭГДСЭН ДҮГНЭЛТ БА ҮНЭЛГЭЭ	8
	ЗӨВЛӨМЖ БА УДИРДЛАГЫН ТАЙЛБАР	
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал	10
	Саналд өгсөн тайлбар	
	АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТУУД	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо
ЗГ	Засгийн Газар
МУ	Монгол улс
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий Газар
УБСЕГ	Улсын Бүртгэл, Статистикийн Ерөнхий Газар
МТБ	Мэдээлэл технологийн баг

ТАНИЛЦУУЛГА

Аймгийн Сонгуулийн хорооны талаарх товч танилцуулга

Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 21 тоот тогтоолоор Хэнтий аймгийн Сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, 7 гишүүн нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байхаар томилсон байна.

УИХ болон аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуульд Хэнтий аймгийн Сонгуулийн хороо, 18 сумын сонгуулийн хэсгийн хороо, 90 санал авах байр байгуулагдан, тэдгээрт төрийн жинхэнэ болон үйлчилгээний 576 албан хаагч, мэдээллийн технологийн багийн 113 ажилтан нийт 689 албан хаагч ажилласан байна.

УИХ болон аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуульд тус аймгаас санал өгөх 46830 сонгогч нэрийн жагсаалтанд бичигдснээс 36227 сонгогч буюу 77.3 хувь нь саналаа өгсөн байна.

СЕХ-ны 2016 оны 172-р тогтоолоор батлагдсан “Техникийн тооллого хийх журам”-ын дагуу санал хураалт дууссаны дараа намуудын ажиглагч нарыг оролцуулан, тэднээс томилсон этгээдээр сугалааг сугалуулж, техникийн тооллогыг эхлэхээс өмнө сонгогдсон санал авах байрны ахлах зохион байгуулагч, зохион байгуулагчид “Сонгуулийн тухай” хуулийн 97 дугаар зүйлийн 97.6-д заасны дагуу санал хураалтын үр дүнгийн мэдээллийг СЕХ-д дамжуулсаны дараа техникийн тооллого эхлүүлсэн.

Техникийн тооллого завсарлагагүйгээр ил тод, нээлттэй зохион байгуулж, нийт 90 санал авах байрнаас 41 санал авах байрыг техникийн тооллогод хамруулж тооллогын явцад зөрчил, маргаан гараагүй байна.

УИХ болон аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуулийг зохион байгуулах Хэнтий аймгийн Сонгуулийн хорооны үйл ажиллагааны зардалд СЕХ-ноос 373367.4 мянган төгрөгийн санхүүжилт ирүүлсэн байна.

УИХ болон аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуулийн санал авах байрны хамгаалалтын шатахуун, нэгж, хоолны зардалд зориулан ЦЕГ-аас Хэнтий аймгийн Цагдаагийн газарт 9279.0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

УИХ болон аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуулийн иргэний бүртгэл, мэдээллийн итгэмжлэгдсэн ажилтны сургалт, тээвэр, урамшуулалд зориулан УБСЕГазраас аймгийн Улсын бүртгэл, статистикийн газарт нийт 49167.1 мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

Гүйцэтгэлийн аудит хийх болсон үндэслэл

Хэнтий аймгийн Аудитын газар нь УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2016 оны 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2016 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн “Төрийн аудитын тухай” хуулийн 15.1.15 заалт, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан “Нийслэлийн болон аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх”-ийн хүрээнд “УИХ болон аймгийн ИТХ-ын сонгуулийн зардлын гүйцэтгэлд гүйцэтгэлийн аудит хийлээ.

АУДИТ ХИЙГДСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Аудитын зорилго

Гүйцэтгэлийн аудитын зорилго нь УИХ болон аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуулийг зохион байгуулж, явуулах үйл ажиллагааны санхүүжилтэд төсвөөс олгосон хөрөнгийг хэрхэн арвич

хямгач, үр ашигтай бөгөөд үр нөлөөтэй ашиглаж байгааг шалгаж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж ҮАГ-т тайлагнаж, аймгийн ИТХ-д танилцуулахад чиглэгдсэн.

Аудитын цар хүрээ

УИХ болон аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуулийн зардалд төсвөөс олгохоор батлагдсан төсөв, гүйцэтгэлийн мэдээ, аймгийн Сонгуулийн хороо, 18 сумын сонгуулийн хорооны анхан шатны баримт, төсөв, гүйцэтгэлийн мэдээ холбогдох бусад баримт материалуудыг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитад ашигласан арга аргачлал

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ АДБОУС, Төрийн хяналт, шалгалтын стандарт, Гүйцэтгэл ба Нийцлийн аудитын гарын авлагууд болон журам ажил гүйлгээг анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авах, тулган баталгаажуулах зэрэг аудитын арга зүйг ашиглан, нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Эрсдлийн үнэлгээ

Эрсдлийн үнэлгээг “Дунд” гэж үнэлсэн

Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийлээ. Үүнд:

- 1.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх
- 2.Төсвийн гүйцэтгэлийн бодитой тайлагнасан эсэх
- 3.Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй эсэх

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа ба бүрэлдэхүүн

Аудитыг 2016 оны 07 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн 8 дугаар сарын 8-ны өдөр хүртэлх хугацаанд аудитор Ү.Төгсжаргал хийж гүйцэтгэлээ.

Хүндрэл ба Бэрхшээл

Аймгийн Сонгуулийн хороо нь сонгууль дууссанаас хойш сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг Сонгуулийн ерөнхий хороонд 30 хоногийн дотор тушаах журамтай.

Гэвч энэ хугацаанд наадмын өдрүүд таарч аудитаар гүйцэтгэлийг баталгаажуулах хоног багатай, 18 сумын сонгуулийн хороо, аймгийн сонгуулийн хороо нийт 19 сонгуулийн хорооны санхүүгийн баримтыг нягтлан шалгахад хүн хүч, цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байсан.


АУДИТЫН ГОЛ АСУУДЛУУД БА ИЛРҮҮЛСЭН ЗҮЙЛ

БҮЛЭГ 1: БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ АРВИЛАН, ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСЭН ЭСЭХ

Хэнтий аймгийн Сонгуулийн хороо нь СЕХ-ноос 373367.4 мянган төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч, гүйцэтгэлээр 370605.9 мянган төгрөгийг зарцуулж, 2761.4 мянган төгрөгийг хэмнэж буцаан төвлөрүүлсэн байна.

СЕХ-ноос олгосон санхүүжилтийг аймаг болон сумдын Сонгуулийн хороонд хуваарилсан байдлыг диаграмаар харуулбал:

/мян.төг/



Дээрх диаграмаас харахад аймгийн Сонгуулийн хороонд 62114.4 мянган төгрөг буюу 16.6 хувийг, Өмнөдэлгэр сумын сонгуулийн хороо 22738.8 мянган төгрөг буюу 6.1 хувийг, Батноров сумын сонгуулийн хороо 23240.3 мянган төгрөг буюу 6.2 хувийг, Хэрлэн сумын сонгуулийн хороо 32109.6 мянган төгрөг буюу 8.6 хувийг үлдсэн 233164.2 мянган төгрөг буюу 62.5 хувийг сумдын сонгуулийн хороодод хуваарилан санхүүжүүлжээ.

Аймгийн болон сумдын Сонгуулийн хороо нь хуваарилсан төсвийн дагуу санхүүжилтээ бүрэн авч, зардлын гүйцэтгэлийг эдийн засгийн ангилалын дагуу гаргаж ирүүлсэн боловч зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган шалгахад дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:

- А. Галшар сумын Сонгуулийн хороо нь бичиг хэргийн зардлаас G-mobile утас, модем зэрэг нийт 630.0 мянган төгрөг, Мөрөн сумын Сонгуулийн хороо нь бичиг хэргийн зардлаас 376.6 мянган төгрөгийн факсын аппарат худалдан авсан байгаа нь Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Сонгуулийн хорооны төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 4 дүгээр зүйлийн 3.2, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.
- В. Жаргалтхаан сумын Сонгуулийн хороо нь байр тохижуулах зардлаас 736.0 мянган төгрөгийн 230 метр гэрлийн утас худалдан авч, бусад сумдын сонгуулийн хороотой харьцуулахад өндөр үнийн дүнтэй материал бэлтгэсэн байна.

- С. Болзошгүй зардалд батлагдсан 3000.0 мянган төгрөгнөөс 1532.1 мянган төгрөгийг Сонгуулийн ерөнхий хороонд сонгуулийн хэсгийн хорооны байруудад гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлаар Онцгой байдлын газарт шилжүүлэх хүсэлт тавьж шийдвэрлүүлсэн байхад үлдсэн 1467.9 мянган төгрөгийг шатахууны зардалд зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэхь заалтыг зөрчсөн байна.
- Д. Өмнөдэлгэр сумын Сонгуулийн хороо нь 5847.0 мянган төгрөгийг бэлнээр гаргаж зарцуулсан байгаа нь Сангийн Сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 6.3 дахь заалтыг зөрчсөн байна.
- Е. Сонгуулийн сургалтын зардалд гүйцэтгэлээр нийт 27715.9 мянган төгрөг зарцуулж, үүнээс 600.0 мянган төгрөг буюу 2.2 хувийг сургалтын түрээсийн байранд, үлдсэн 27115.9 мянган төгрөг буюу 97.8 хувийг сургалтын томилолт, цайны материал, сургалтын хоол зэрэг зардлуудад зарцуулсан байгаа нь сумдын сургалтын зардлыг хүрэлцээтэй төсөвлөж хуваарилсан бөгөөд сургалтын зардлыг бичиг хэрэг, цайны материал гэх мэтээр зардлыг бодитой тооцож олгоогүй, зардлыг аривлан хэмнэх боломжийг ашиглаж чадаагүй байна.

1.2 УБСЕГ-аас аймгийн Улсын бүртгэл, статистикийн газарт 2016 оны сонгуулийн сургалтын зардалд 1271.2 мянган төгрөг, итгэмжлэгдсэн ажилтны сургалтанд 20192.9 мянган төгрөг, сургалт болон тээврийн зардалд 9655.0 мянган төгрөг, итгэмжлэгдсэн ажилтны цалинд 18048.0 мянган төгрөг нийт 49167.1 мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

Аймгийн Улсын бүртгэл, статистикийн газар нь УИХ болон аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуулийн зардлыг бүрэн зарцуулсан боловч удирдах дээд байгууллагын шийдвэргүйгээр 6131.9 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулж Төсвийн тухай хуулийн 16.5.5, 6.4.1 заалтуудыг зөрчсөн зөрчил илэрлээ. Үүнд:

- А. Бичиг хэргийн зардлаас байгууллагын шуудан үйлчилгээний газарт төлөх 2015 оны жилийн эцсийн 4531.9 мянган төгрөгийн өрийг барагдуулсан байна.
- В. Тээвэр шатахууны зардлаас 1600.0 мянган төгрөгийн автомашины сэлбэг авсан байна.

1.3 ЦЕГ-аас аймгийн Цагдаагийн газарт сонгуулийн хоолны зардалд 7365.0 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 914.0 мянган төгрөг, шатахууны зардалд 1000.0 мянган төгрөг нийт 9279.0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэж зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

ДҮГНЭЛТ

Дээрх зөрчил гарсан шалтгаан, үр дагаварыг шинжлэн дараах дүгнэлтэд хүрч байна.

Сонгуулийн зардлаас хөрөнгө бэлтгэж, байгууллагын өрийг төлж, зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй, хэмнэх боломжтой зардлыг хэмнэж ажиллаагүй зэргээс харахад сонгуулийн зардлын төсөв хүрэлцээтэй бөгөөд түүнийг хэмнэх талаар Аймгийн сонгуулийн хороо болон сумын сонгуулийн хороо санаачлага гаргаж ажиллаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

1. Сонгуулийн зардлаас төсвийн байгууллагын хөрөнгийн болон урсгал зардалд зарцуулахгүй байх
2. Сургалтын зардлыг бодитой тооцож зардлыг хэмнэх талаар санаачилгатай ажиллах
3. Болзошгүй зардлыг гамшигын нөхцөл байдал үүссэн үед СЕХ-ноос тухайн сумын сонгуулийн хороонд зардлыг шилжүүлж байх

БҮЛЭГ 2: ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ БОДИТОЙ ТАЙЛАГНАСАН ЭСЭХ

2.1 Хэнтий аймгийн Сонгуулийн хорооны үйл ажиллагааны зардал нийт дүнгээрээ хэтрээгүй бөгөөд үлдэгдэл 2761.4 мянган төгрөгийг СЕХ-нд төвлөрүүлсэн байна.

УИХ болон аймгийн ИТХурлын 2016 оны сонгуулийн зардлын гүйцэтгэл

/мян төг/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Саналын хуудас устгах зардал	1000.0	800.0	200.0
2	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	250.0	250.0	0.00
3	Сургалтын зардал	29283.0	27715.9	1567.0
4	Бичиг хэргийн зардал	22400.0	22398.7	1.3
5	Шуудан холбооны зардал	22700.0	22470.6	229.4
6	Унааны зардал	47000.0	46786.3	213.6
7	Хууль тогтоомж сурталчлах зардал	8000.0	7992.4	7.5
8	Санал авах байр бэлтгэх зардал	18000.0	18000.0	0.00
9	Саналын хуудас хүргэх	5139.0	5130.9	8.0
10	ICP машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх	14680.0	14428.9	251.0
11	MTБ-ийн мэдээ дамжуулах зардал	600.0	600.0	0.00
12	Томилолтын зардал	5053.0	5019.0	34.0
13	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх	4410.0	4263.0	147.0
14	Сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	151601.2	151601.2	0.00
15	Сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал /MT/	30051.2	30051.2	0.00
16	Болзошгүй зардал	3000.0	3000.0	0.00
17	Бичиг хэргийн ажилтан, нягтлан бодогч нарын урамшуулал, хоолны зардал	1700.0	1700.0	0.00
18	Төрөл бүрийн үнэмлэх хэвлүүлэх	600.0	600.0	0.00
19	Сурталчилгааны материал хүргэх зардал	7900.0	7797.5	1024.7
20	Дүн	373367.4	370605.9	2761.4

Маягт хэвлүүлэх зардал, санал авах байр бэлтгэх зардал, MTБ-ийн мэдээ дамжуулах зардал, сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал, MTБ-ийн хоолны зардал, урамшуулал, болзошгүй зардал, бичиг хэргийн ажилтан, нягтлан бодогч нарын урамшууллын зардлыг төсвийн дагуу зарцуулж бусад зардал 8.0-1567.0 мянган төгрөг хэмнэгдэж 2761.4 мянган төгрөгийг СЕХ-нд буцаан төвлөрүүлсэн байна.

УИХ болон аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуулийн зардлыг сум болгоны анхан шатны баримтын тулган шалгасан боловч цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал нөхцөл байдлаас шалтгаалан болзошгүй зардал, сонгуулийн хороонд ажилласан ажилтнуудын мөнгөн урамшуулал, хоолны зардал, нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтны хоолны зардал, мөнгөн урамшуулал, эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал зэргийг түүвэрлэн шалгахад зөрчил илрээгүй байна.

2.2 УИХ болон аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуулийг зохион байгуулах үйл ажиллагааны зардлаас нийт 3962.5 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж үүнээс 3259.0 мянган төгрөгийн бараа материалыг орлого авч 536.5 мянган төгрөгийн бараа материалыг орлогод аваагүй зөрчил илэрлээ.

ДҮГНЭЛТ

Дээрх зөрчил гарсан шалтгаан, үр дагаварыг шинжлэн дараах дүгнэлтэд хүрч байна.

Сонгуулийн зардлаар бэлтгэсэн бараа материалыг сонгууль дууссаны дараа данс бүртгэлд тусгаагүй байгаа нь бараа материал үрэгдэх шамшигдах нөхцөл бүрдсэн байна.

ЗӨВЛӨМЖ

Сонгуулийн зардлаар бэлтгэсэн бараа материалыг сонгуулийн дараа комисс томилж орлогод авч байх

БҮЛЭГ 3: ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ҮР ДҮНТЭЙ ЭСЭХ

Аймгийн сонгуулийн хорооноос сумдын хэсгийн хороо, байршил, хүн амын тооноос хамаарч зардал тус бүрээр төсөв хуваарилаж төсвийн дагуу 2016 оны 05 сарын 25-наас 06 сарын 27-ныг хүртэлх хугацаанд нийт 6 удаагийн санхүүжилтээр 311252.9 мянган төгрөгийг сумдын сонгуулийн хороодод хуваарилаж олгосон байна.

Аймаг болон сумдын сонгуулийн хороо нь хуваарилсан төсвийн дагуу хөрөнгийг зарцуулж тайлагнасан боловч

- a. Норовлин сумын Сонгуулийн хороо нь сургалтын зардлаас томилолтыг тооцож олгохдоо сургалтанд хамрагдсан хүмүүсийн нэрийн жагсаалт үйлдэн 288.0 мянган төгрөгийг хувь хүний харилцах дансанд шилжүүлсэн
- b. Батширээт сумын Сонгуулийн хороо нь огт бөглүүлээгүй хоосон томилолтыг баримт болгон 128.0 мянган төгрөгийг хүн тус бүрийн харилцах дансанд шилжүүлсэн
- c. Сумдын сонгуулийн хороод нь байр тохижуулах зардлаас хэдэн төгрөгийн материал бэлтгэсэн, сонгуулийн дараа тэдгээр бараа материалыг хаана бүртгэлд авч хүлээн авсан, уг бараа материалыг цаашид дараагийн сонгуульд ашиглах боломж байгаа эсэх талаар бүртгэл мэдээлэл байхгүй зэрэг зөрчил дутагдал илэрлээ.

ДҮГНЭЛТ

Дээрх зөрчил гарсан шалтгаан, үр дагаварыг шинжлэн дараах дүгнэлтэд хүрч байна.

Сургалтын зардлаас олгосон томилолтыг анхан шатны бүрдэл дутуу баримтаар томилолтын зардлыг тооцож олгосон, сумдын сонгуулийн хорооны гүйцэтгэлийн тайлан, анхан шатны баримтыг хүлээж авсан боловч сонгуулийн зардлаас хэдэн төгрөгийн материал бэлтгэсэн, хаана орлого авсан талаарх мэдээлэл тодорхойгүй байгаа зэрэг нь хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

ЗӨВЛӨМЖ

1. Сумын хэсгийн хороо болон сонгуулийн хороо анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллах

Аудитаар нийт 9342.4 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 4531.9 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоолоо.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ БА ҮНЭЛГЭЭ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

Сонгуулийн зардлаас хөрөнгө бэлтгэж, байгууллагын өрийг барагдуулж, зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй, арвилан хэмнэх зарчмыг баримталж ажиллаагүй, сургалтын зардлаас олгосон томилолтыг анхан шатны бүрдэл дутуу баримтаар томилолтын зардлыг тооцож олгосон, сонгуулийн зардлаас хэдэн төгрөгийн бараа материал бэлтгэсэн, хаана

орлого авсан талаарх мэдээлэл хангалтгүй байгаа зэргээс харахад сонгуулийн зардлын төсөв хүрэлцээтэй бөгөөд түүнийг хэмнэх талаар санаачилга гаргаж ажиллаагүй, хөрөнгийн зарцуулалтад тавих шат шатны дотоод хяналт хангалтгүй байна гэж үзлээ.

ЗӨВЛӨМЖ БА ДЭЭД БАЙГУУЛЛАГАД УЛАМЖЛАХ САНАЛ

Сонгуулийн Ерөнхий хороонд

1.Болзошгүй зардлыг гамшгийн нөхцөл байдал үүссэн үед СЕХ-ноос тухайн сумын сонгуулийн хороонд зардлыг шилжүүлж байх

Аймгийн Сонгуулийн хороонд

1. Сургалтын зардлыг бодитой тооцож, зардлыг хэмнэх талаар тодорхой заавар чиглэлийг сумдын сонгуулийн хороонд өгч ажиллах

Сумын Сонгуулийн хороонд

1.Сонгуулийн зардлаас төсөвт байгууллага урсгал зардал болон хөрөнгө бэлтгэдэг явдлыг таслан зогсоож, бэлтгэгдсэн бараа материалыг данс бүртгэлд бүртгэж байх

2. Сумын хэсгийн хороо болон сонгуулийн хороо санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллах

3.Сумдын сонгуулийн хорооны нягтлан бодох бүртгэлийг мэргэжлийн нягтлан бодогчоор гүйцэтгүүлэх

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН САНАЛ БА ТАЙЛБАР

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал



Төрийн аудитын тухай хуулийн 19.3.1 дах хэсэгт заасны дагуу гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд санал авахаар аймгийн Аудитын газрын 2016 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 167 тоот албан бичгээр Аймгийн Сонгуулийн хорооны удирдлагад хүргүүлж хариуг 2016 оны 08 дугаар сарын 18-ны 54 тоот албан бичгээр авч тайлангийн төсөлтэй холбоотой дараах 2 саналыг ирүүлснийг судалж үзээд аудитын тайланд дараах өөрчлөлт орууллаа.

Үүнд:

1. Сумдын сургалтын зардлыг хүрэлцээтэй төсөвлөж хуваарилсан бөгөөд сургалтын зардлыг цайны материал, бичиг хэргийн материал гэх мэтээр гарах зардлыг бодитой тооцож олгоогүй, зардлыг хэмнэх боломжийг ашиглаж чадаагүй гэж тайлангийн Бүлэг 1-ийн Е хэсэгт өөрчлөлт оруулав.

2. Сумын сонгуулийн хороонд мэргэжлийн нягтлан бодогч ажиллуулах гэж зөвлөмжид нэмж оруулахаар тогтов.

Аудитын тайлан бичсэн:
Аудитор Ү.Төгсжаргал

